


БАТЛАВ, ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН
СУМЫН ЗАСАГ ДАРГА ХҮРЭЛЧУУД

БАТЛАВ, ТҮШТҮЙНС БЯАНГҮМЭН" ЗГБХН
ЗАХИР Г. ГАНГИЧУЛУУН



**БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ
ОЛБОРЛОХ ГЭРЭЭ**

"Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 2.4, 3.1.3, 6.1.3-г заасны дагуу нэг талаас Дорнод аймгийн Баяндун сумын Засаг дарга Х. ХҮРЭЛЧУУН (цаашид "Засаг дарга" гэх), нөгөө талаас "ТҮШИГ БЯАНГҮМЭН" ЗГБХН нөхөрлөл (цаашид "Бичил уурхай эрхлэгч этгээд" гэх)-ийг төлөөлж захирал Г. ГАНГИЧУЛУУН нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харицан тохиролцож 2018 оны 09 дугаар сарын 07-ны өдөр энэхүү гэрээг (цаашид "Гэрээ" гэх) БАЯНДУН суманд байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь БАЯНДУН сумын ТҮРГЭН багийн НҮХТ нэртэй газарт орших 5.0 гектар талбайд журмын 6.1.3-г заасны дагуу хайлуур жонш олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэлнэ.
- 1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сумын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

Хоёр. Сумын Засаг даргын эрх, үүрэг

- 2.1. Сумын Засаг дарга нь "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 6 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
 - 2.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршлын зургийг гэрээнд хавсаргах;
 - 2.1.2. хөг хаягдлын нөгийн байршлын тогтоох;
 - 2.1.3. бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох;
 - 2.1.4. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдэй тохиролцооны үндсэн дээр зохих хөрөнгийг төвлөрүүлэх;
 - 2.1.5. бичил уурхайн ажилтнуудад (цаашид "ажилтан" гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах;

2.1.6. энэхүү гэрээгээр хү гэсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;

2.1.7. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

2.1.8. хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох.

Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

3.1. Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. бичил уурхай эрхлэгч этгээд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;

3.1.2. ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах;

3.1.3. суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах;

3.1.4. гэрээгээр олгосон талбайд нөхөр юм, хоршоо, бүртгэгдээгүй нохорлолийн гишүүн бус этгээдийг ажиллуулахгүй байх;

3.1.5. байгаль орчныг хамгааж, гол, гөрхв, булаг шанд, усг цэгийг бохирдуулахгүй байх;

3.1.6. бичил уурхайн аюулгүй байдлыг дүрмийг дагаж мөрдөх, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.7. хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сургалчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах;

3.1.8. ашигт малтмалын ашиглан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх;

3.1.9. үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, гэрээгээний хэрэгсэл ашиглахгүй байх;

3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нохорлол, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см³ хүргэх багтаамжтай догоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах;

3.1.11. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах / төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх;

3.1.12. нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах;

3.1.13. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх;

3.1.14. олборлосон ашиг, малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээдэд худалдах;

3.1.15. ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар төлөх;

3.2. Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж, талбайг хүлээлгэн өгсний дараа ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах.

Дорov. Харилцан хүлээх үүрэг

4.1. Гэрээнд талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтарч ажиллана.

4.2. Гэрээний дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох явцад байгаль орчин, бусад этгээдэд хохирол учруулсан тохиолдолд бичил уурхай эрхлэгч этгээд уг хохирлыг барагдуулах үүрэгтэй. Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчинд учруулсан хохирлыг арилгуулахыг бичил уурхай эрхлэгч этгээдээ шаардана.

4.3. Талууд энэхүү гэрээний онцгойг жил бүр хамтран дүгнэж, аймаг (нийслэл)-ийн Засаг даргад дараа оны 1 дүгээр сард багтаан тавилгана.

Тав. Маргаан шийдвэрлэх

5.1. Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

5.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

Зургаа. Гэрээний хүчин төгөлдөр болгох

6.1. Энэхүү гэрээ нь 2018 оны 09 сарын 09 өдрөөс гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2. Бичиг уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.3. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.


Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуу талыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.2. Энэхүү гэрээнд оруулаан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

Гэрээ байгуулсан:

ДОРНОД аймгийн БАЯНДУУ сумын
Засаг дарга Х. ХҮРЭДЦОЮУН



ДОРНОД АЙМАГ
ТҮҮНДЭГ БАЯНГҮМӨН ЗГБХН
Засаг дарга ТҮҮНДЭГЧИГЧ
Б. АНГУУН
ХТҮ222403384721
2110200103

